



**ҮЙЛДВЭРЛЭЛ ХУДАЛДААНЫ  
"СҮҮ" ХУВЬЦААТ КОМПАНИ**

Улаанбаатар 107119 Сэлэнгэ дүүрэг  
Үйлдвэрний зөвлөлийн гудамж 17  
Утас: 9 76117222 Факс: 976 7601991  
E-mail: info@suu.mn, suu@suu.mn, suu@suu.mn

**"МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН  
БИРЖ" ТӨХК-д**

2020.04.08 04/631

**Мэдээлэл хүргүүлэх тухай**

Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая.

"Сүү" ХК-ийн 2020 оны "Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал" 2020 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 15:00 цагаас хуралдахаар товлогдсон билээ.


Монгол улсын засгийн газрын 2020 оны 03 дугаар сарын 22-ны өдрийн 102 тоот тогтоолоор өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахыг хориглосон.

Иймд тус компани Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдөр гаргасан Хувьцаа эзэмшигчдийн хурлыг цахим хэлбэрээр хийх уриалгыг дэмжиж, 2020 оны Хувьцаа эзэмшигчдийн хурлаа товлосон өдөр буюу 2020 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 15:00 цагт цахим хэлбэрээр зохион байгуулахаар болсныг мэдэгдэж байна.

Хавсралт: 1 хуудастай

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



М.МАНДХАЙ



## “СҮҮ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Монгол улсын Засгийн газрын 2020 оны 03 сарын 22-ны өдрийн 102 тоот тогтоолоор өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгасантай холбогдуулан “Сүү” ХК-ийн 2020 оны “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал”-ыг 2020 оны 04 сарын 17-ны өдрийн 15:00 цагт компанийн албан ёсны <https://www.facebook.com/mongolmilk.mn/> фэйсбүүк хуудсаар дамжуулан, олон нийтэд нээлттэй явуулах болсныг мэдэгдэж байна.

Хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ. Үүнд:

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгөх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудал,
2. Хувьцаа нэмж гаргах, хувьцаа нэмж гаргах төслийг батлах тухай асуудал,
3. Нэмж гаргаж буй хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хувьцаа эзэмшигчдэд эдлүүлэх эсэх асуудал,
4. Компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудал,
5. Ногдол ашгийн талаар Хувьцаа эзэмшигчдэд мэдээлэл хүргэх тухай асуудал,

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гарах бүртгэлийн өдөр нь 2020 оны 03 дугаар сарын 27-ны өдөр байна.

Хувьцаа эзэмшигч та бүхэн хуралд оролцохын тулд:

1. Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, Үйлдвэрчний эвлэлийн гудамж-37 хаягт орших “Сүү” ХК-ийн байранд **2020 оны 04 дүгээр сарын 09-ний өдрөөс 2020 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийг дуусталх хугацаанд ажлын өдрүүдэд 10:00-14:00 цагийн хооронд өөрийн биеэр, иргэний үнэмлэх /Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ хуулийн шаардлага хангасан итгэмжлэл олгосон байна/-тэй ирж бүртгүүлнэ.**
2. Хувьцаа эзэмшигч нь өөрийн харилцагч Үнэт цаасны компаниар дамжуулан санал авах хуудсаар саналаа урьдчилж өгөх боломжтой бөгөөд санал авах хуудсаар санал авах хугацаа 2020 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 14:00 цагт дуусна.

Хувьцаа эзэмшигч нь хурлын материалтай компанийн байранд хүрэлцэн ирж, эсвэл өөрийн харилцагч Үнэт цаасны компаниар дамжуулан танилцах боломжтой.

Нэмэлт мэдээлэл:

Хувьцаа эзэмшигч хурлын үеэр санал хэлж, асуулт асуухдаа компанийн албан ёсны <https://www.facebook.com/mongolmilk.mn/> фэйсбүүк хуудсанд мессеж бичих, эсвэл [info@mongolmilk.mn](mailto:info@mongolmilk.mn) цахим хаягт и-мэйл илгээх боломжтой бөгөөд ийнхүү мессеж бичих, имэйл илгээхдээ хувьцаа эзэмшигч өөрийн овог, нэр, регистрийн дугаарыг үнэн зөв бичсэн байх ёстойг анхаарна уу.

Харилцах утас: 80093311

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС